

МОНГОЛ ШҮЛЭГТ ИХЭСГЭЛ, БАГАСГАЛЫН АРГААР УРАН ДҮРСЛЭЛ  
БҮТЭЭЖ ИРСЭН ТУРШЛАГА, ЗҮЙ ТОГТОЛ

Г.Галбаяр

**Түлхүүр үг:** монгол шүлэг, уран дүрслэл, ихэсгэл, багасгал, аман зохиол, Монголын Нууц Товчоо, Алтан товч, Д.Нацагдорж, Б.Явуухулан, Б.Лхавасүрэн

**Summary**

One of the many ways of employing figurative language in Mongolian poetry is the combination of the opposing literary devices of hyperbole and litotes. When used correctly, hyperbole and litotes enhance the meaning of a poem, deepening its semantic content and adding artistic features. In Mongolian oral folklore, hyperbole and litotes are increasingly used in symbolic expressions with extended meanings, words of praise, blessings, and benedictions, as well as in poetry involving communication in which the speakers each have the intention of prevailing over the another. In Mongolian epics, hyperbole and litotes are used at the classical level, appearing widely throughout works of medieval Mongolian literary works such as the *Secret History of the Mongols* and Luvsandanzan's *Altan Towch* [*Golden Summary*]. However, hyperbole and litotes are comparatively less used in modern times due to the development of society and the mentality of readers placing more emphasis on tangible and documented phenomena. This article looks at hyperbole and litotes in the poems of D.Natsagdorj, B.Yawuukhulan, and B.Lkhagwasüren, examining how they have created unique imagery by means of exaggeration and understatement, and further illustrating the changes and innovations that have occurred in the development and evolution of figurative hyperbole and litotes.

**Удиртгал**

Шүлэгт “үг шууд утгаараа байх нь харьцангуй ховор, дүрслэн илэрхийлэх, сэтгэл хөдөлгөх шинжийг нээн үзүүлэх гол нөхцөл болсон үгийн шилжсэн утга зонхилно” (Баярсайхан, 1990:75). Шилжсэн утгын илэрхийлэл бол уран дүрслэлийн ур маягуудын хэрэглээ юм. Тиймд уран зохиол, тэр дундаа шүлэгт уран дүрслэлийн аргууд онцгой чухал үүрэг гүйцэтгэдэг. Оросын уран зохиолын онолч, шүүмжлэгч В.Г.Белинский “шинжлэх ухаан бол баталдаг, уран зохиол бол дүрсэлдэг” гэж хэлсэн нь уран зохиол юмыг шууд илэрхийлэхгүй, үгийн утгыг далдлан дүрсэлдэг болохыг цохон дурдсан хэрэг.

Энэ удаа монгол шүлэгт ихэсгэл, багасгалын аргаар уран дүрслэл бүтээж ирсэн туршлага, түүний зүй тогтлыг тодруулан үзэж байна. Судалгааны эх хэрэглэгдэхүүн болгож ардын аман зохиолын хүрээ хамаарал дахь шүлгүүдийг Д.Цэрэнсодном “Монгол аман зохиолын тайлбарт дээж бичиг” (Уб., 2012) бүтээлд орсон эхүүд, “Монгол Жангарын тууль” (Уламжлалт эхийг баримтлан нэмэн засварлаж шүлэглэсэн Цэндийн Дамдинсүрэн. (Уб., 2008)), эртний бичгийн уран зохиолын шүлгүүдийг “Монголын Нууц Товчоон” (1228, /1240?) болоод Лувсанданзаны “Алтан товч” (1655), Ц.Дамдинсүрэнгийн “Монгол уран зохиолын дээж зуун билиг оршвой”

(Уб., 1959), орчин үеийн уран зохиолын шүлгүүдийг Д.Нацагдорж “Бүрэн зохиол-1” (Уб., 2016), Б.Явуухулан “Түүвэр зохиол” (Уб., 1985), Б.Лхагвасүрэн “Бүрэн түүвэр” III боть (Уб., 2006) түүвэр зохиолуудын хүрээнд авч үзэв. Өгүүлэн буй түүврүүдэд орсон шүлгүүдийн 80 орчим хувь нь уран дүрслэлийн аль нэг аргаар бүтсэн болох нь тодорхой байна. Уран дүрслэлийн аргаар дүрслэл бүтээсэн шүлгүүдийг нарийвчлан ажиглавал 1. Адилтгал зүйрлэлийн аргыг ашигласан нь 55 орчим хувь 2. *Ихэсгэл, багасгалын аргыг ашигласан нь 15 орчим хувь* 3. Төлөөлөл, тойрууллын аргыг ашигласан нь 10 орчим хувь 4. Хүншүүлэл, юмшууллын аргыг ашигласан нь 5 орчим хувь 5. Ёгтлол, егөөдлийг аргыг ашигласан нь 5 орчим хувь 6. Бэлгэдлийн аргыг ашигласан нь 5 орчим хувь 7. Бусад аргыг ашигласан нь 5 орчим хувийг эзэлж байна. Нэг шүлэгт хоёр ба түүнээс дээш уран дүрслэлийн арга хэрэглэсэн нь тодорхой хэмжээгээр байх ба түүнийг тус тусад нь авч үзэв. Энэ тоо баримт монгол шүлэг ихэвчлэн уран дүрслэлийн аргаар бичигддэг, тэрхүү уран дүрслэлийн аргуудаас адилтгал зүйрлэлийн арга илт тэргүүлэх байр суурьтай ч ихэсгэл, багасгалын арга тодорхой хэмжээгээр ашиглагдаж ирсэн болохыг харуулж байна.

### **I. Уран дүрслэлийн ихэсгэл, багасгалын аргыг судлан шинжилсэн нь**

Хэлний нэгжүүдийн утгыг зориуд шилжүүлэн салаа утга үүсгэж уран дүрслэл бүтээснийг дүрслэлийн ур маяг гэж нэрлэнэ. Уран дүрслэлийн хэтрүүллийн арга нь ихэсгэл (Hyperbola/ Гипербола) ба багасгал (Litotes/Литота) гэсэн хос эсрэгцсэн аргаас бүрдэнэ. “Аливаа зүйлсийн шинж чанарыг ихэсгэн хэтрүүлж шилжсэн утгаар нь дүрслэхийг ихэсгэл”, “аливаа зүйлийн эсрэг талын сөрөг үнэлэмжийг уран сайхнаар хошигнох юм уу ёжлох маягаар утга далдлан багасгаж дүрслэхийг багасгал” (Kathleen Morner нар, 1998:102, 115) гэж тодорхойлсон байна. Эртний Энэтхэгийн зохист аялгуун онолч Дандин “Зохист аялгуун толь” бүтээлдээ ихэсгэлийг гайхамшгийн чимэг гэж нэрлээд түүнийг доорх дөрвөн аргаар харуулсан байна.

1. *Тэрхүү сайшаагдах юм нь орчлонгийн ямар нэг зүйлээс хэтэрсэн давуу сайхан байх.*
2. *Түүний хэтэрхий байдалд эргэлзэхүйц байх.*
3. *Хэтэрсэн сайхан нь илэрхий нотлогдохуйц байх.*
4. *Гайхмаар, хачирхмаар сайхан сэтгэгдэл төрүүлэхээр байх ёстой*  
(Дандин, 2014:34-35).

Уран дүрслэлийн ихэсгэл, багасгалын ур маяг монгол хэлэнд ямар үүрэг, зүй тогтолтой хэрэглэгдэж байгааг хэл шинжээч, судлаач М.Базаррагчаа, Д.Отгонсүрэн, Ц.Сүхбаатар нар судалсаар иржээ. Уран зохиол, тэр дундаа шүлэгт уран дүрслэл бүтээж ирсэн онцлогийг уран зохиол судлаач Ш.Гаадамба, С.Дулам, Ц.Хасбаатар, С.Байгалсайхан, Д.Галбаатар нар авч үзсэн байна. Тухайлбал, хэл шинжээч, эрдэмтэн М.Базаррагчаа “Тухайн нэг зүйлийг ялгах бус, бүхэлд нь хэтрүүлэхийг ихэсгэл, эсвэл багасгах гэнэ” (2003:29) хэмээн тодорхойлоод зохих жишээ баримтаар багатган өгүүлсний зэрэгцээ ихэсгэл, багасгалын тухай судалсан судлаачдын судалгаа шинжилгээний бүтээлүүдийг нэгтгэн дүгнэж өгүүлсэн байна. Судлаач уран дүрслэлийн ихэсгэл, багасгалын арга нь дүрсэлж байгаа зүйлээ бусад зүйлтэй харьцуулж авч үздэггүй, зөвхөн түүнийг ямар нэг шинжээр нь хэтрүүлэн дүрсэлж, тэрхүү хэтрүүлсэн дүрслэлээрээ бусдад хүчтэй нөлөөлдгийг онцлон өгүүлсэн байна. Бусдад нөлөөлөх нөлөө гэдэг нь тухайн хэтрүүлсэн дүрслэгдэхүүн зохиолд дүрслэгдсэн бусад дүрүүдэд нөлөөлж тэднийг айлгах, ичээх зэргээр өөртөө татах, хүсэл зорилгоо биелүүлэх шинжийг илтгэхийн зэрэгцээ уншигчдыг өөртөө татах, бишрүүлэх зэрэг давхар үүргийг хадгалдаг байна.

Найруулга зүйч Д.Отгонсүрэн “Д.Нацагдоржийн зохиолын хэл найруулга уран сайхны онцлог” (1984) бүтээлдээ Д.Нацагдорж уран дүрслэлийн ур маягуудыг хэрхэн ашигласныг ихэсгэл, багасгалыг хэтрүүлэл гэсэн ерөнхий нэрээр авч үзжээ. Судлаач “ер нь уран зохиолын найруулгад их ашигладаг хэтрүүллийг бодит байдалд байгаа юм үзэгдэл, түүний шинжийг их болгож хэтрүүлсэн үү, бага болгож хэтрүүлсэн үү гэдгээр нь ихэсгэл, багасгал гэж хоёр

ангилж болно” (1984:34) гээд ихэвчлэн Д.Нацагдоржийн өгүүллэгүүдийн дүрслэлийн жишээ баримтад тулгуурлан өгүүлжээ. Судлаач Д.Отгонсүрэн уран дүрслэлийн ихэсгэл, багасгалын аргыг угтаа бол дүрслэлийн нэг ур маяг гэж үзсэн нь гярхай зөв ашиглалт аж. Тодруулбал, ихэсгэл, багасгал бол аливаа зүйлийг хэтрүүлэн дүрслэх нэг л сэтгэлгээний илэрхийлэл. Тэрхүү хэтрүүлэх сэтгэлгээ их хэтрүүлэхээрээ ихэсгэл, бага хэтрүүлэхээрээ багасгал болдог билээ. Ерөөс уран дүрслэлийн хос эсрэгцсэн аргууд өнгөн талдаа ижил хэмнэл бүхий зүй тогтол үүсгэн орших ч дотоод мөн чанартаа сэтгэлгээний нэг л ойлголт гэдэг нь тодорхой байна. Ийм учир бид өмнө “метафор” буюу адилтгал зүйрлэлийг харьцуулан жиших сэтгэлгээний нэг л илэрхийлэл тул хамтад нь авч үзэх нь зөв юм байна гэж үзсэн билээ. Зайлшгүй ялгах шаардлага гарвал төрөл ижил зүйлсийг харьцуулахыг адилтгал (Simile/сравнение), төрөл бус зүйлсийг харьцуулахыг зүйрлэл (Metaphor/метафора) гэж нэрлэж болох тухай санал<sup>1</sup>-аа дэвшүүлсэн.

Найруулга зүйч Ц.Сүхбаатар “Юм үзэгдлийн аль нэг шинж чанарыг бодитой байж болох бололцооноос нь хэт ихэсгэн давуулсан буюу бууруулсан найруулгын ур маягийг хэлнэ. Хэтрүүллийг бодит бололцооны талаас нь авч үзэхэд биелэгдэх нь эргэлзээтэй буюу биелэгдэх бололцоогүй байдалтай байна. Зохиогч хэтрүүллийг хэрэглэхдээ уншигч буюу сонсогчид үнэмшүүлэх зорилго тавьдаггүй, харин энэ бол найруулгын нэгэн арга юм гэдгийг тэдний мэдэхэд дулдуйдна. Үүнийг оновчтой хэрэглэснээр дүрслэл уран яруу болж, хүчтэй сэтгэгдэл төрүүлнэ” (2007:322) хэмээн судлаач Д.Отгонсүрэнтэй ижил санал дэвшүүлсэн ч ихэсгэл, багасгалын аргын мөн чанар, үүрэг талыг нь найруулга зүйн үүднээс илүү тодорхой болгож өгүүлсэн байна.

Уран зохиол судлаач, эрдэмтэн Ш.Гаадамба “Урнаар юмын дүрийг тод товгор өгүүлэхийн нэг арга бол ихэсгэл багасгал хоёр болно. Уран зохиолд юмын онцлог тал, чанар, шинжийг гойд товгойлгох зорилгоор үнэн байдалд байдгаас нь хэт их болгох чиглэлээр үгийн утгыг шилжүүлэн хэрэглэхийг ихэсгэл гэнэ. ... Юмын бага хэмжээ чанарыг тод болгохын учир жижиг тийш нь хэтрүүлэн дүрслэхийг багасгал гэнэ” (1989:129-130) хэмээн тодорхойлоод Монголын Нууц Товчоо зохиолоос жишээ татан тайлбарласан байна. Ш.Гаадамбын уг тодорхойлолт нь уран дүрслэлийн ихэсгэл, багасгалын арга үгийн үндсэн утгыг шилжүүлэн өөрчилж, өөр утга илэрхийлдэг тул юмсын дотоод мөн чанар, шинжийг тодруулан товгойлгоход илүү ашиглагддаг онцлогтой гэж өгүүлсэн байна.

Уран зохиол судлаач С.Дулам, Ц.Хасбаатар нар “Яруу сайхны сэтгэгдэл төрүүлэхийн үүднээс юм, үзэгдэл, үйл явдлын аль нэг шинж төрхийг уран сайхнаар ихэсгэн дүрслэхийг хэтрүүлэл гэнэ. ... Багасгал нь хэтрүүллийн эсрэг юм үзэгдэл, үйл явдлын шинж байдлыг ихэсгэн хэтрүүлэх биш, “багасган хэтрүүлэх” уран сайхны дүрслэлийн арга хэрэглүүр юм.” (1980:157, 158) гэж тодорхойлоод “Жангар”, “Хан Харанхуй” тууль, “Төө алаг шартай эмгэн” үлгэр, Ч.Лодойдамбын “Тунгалаг тамир” романаас жишээ баримт татан тайлбарласан байна.

Уран зохиол судлаач С.Байгалсайхан “Юмс үзэгдлийн шинж чанарыг дүрслэхдээ ихэсгэн үзүүлэхийг ихэсгэл гэж нэрлэнэ. ... Хэтрүүллийн эсрэг дүрслэлийн ур маягийг багасгал гэнэ.” (1995:101-102) хэмээн товч тодорхойлоод энэ дүрслэлийн арга монгол ардын аман зохиолд түлхүү ашиглагдаж байсан онцлогийг өгүүлэхийн зэрэгцээ баатарлагийн тууль, үлгэр, домог тэргүүтнээс жишээ татан дэлгэрүүлэн тайлбарласан байна.

Уран зохиол судлаач Д.Галбаатар “Урлаг, уран зохиолд дүр бүтээх, дүрслэгдэхүүний яруу сайхныг нээх зорилгоор юмс, үзэгдлийн шинж төрх, байр байдлыг байгаагаас нь ихэсгэн хэтрүүлж, хүч нэмэгдүүлэн сүрлэг болгож дүрслэх арга. Юмс үзэгдлийг өсгөж хэтрүүлснийг ихэсгэл, харин бууруулж хэтрүүлснийг багасгалын уран маяг гэдэг.” (2012:202) хэмээн уран дүрслэлийн ихэсгэл, багасгалын аргыг онолын үүднээс оновчтой тодорхойлсон байна.

<sup>1</sup> Галбаяр Г. Монгол шүлэгт адилтгал зүйрлэлийн аргаар уран дүрслэл бүтээсэн зарим онцлог. ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн ХЭЛ ЗОХИОЛ СУДЛАЛ эрдэм шинжилгээний сэтгүүл. Боть XIII (45). Уб., 2020. 232-250 дугаар тал.

Өгүүлэн буй хэтрүүллийн арга болох ихэсгэл, багасгалын тухай онолын ойлголт хийгээд дотоод, гадаадын судлаачдын судалгааны үр дүнг нэгтгэж үзвэл юмс үзэгдлийн аль нэг шинж чанарыг байх хэмжээнээс нь хэт давуулсан, эсвэл хэт бууруулсан уран дүрслэлийн ур маягийг хэтрүүлэл (overcorrection) гэдэг байна. Хэтрүүлээр бодит байдал дээр байх боломжгүй зүйлийг илэрхийлдэг ч энэ нь бусдыг итгүүлэн үнэмшүүлэх зорилготой бус, харин яруу сайхны сэтгэгдэл төрүүлэх, тэрхүү яруу сайхны сэтгэгдлээр нь дамжуулан юмсын шилжсэн утга санааг илэрхийлдэг байна. Тиймээс уран дүрслэх арга бол аливаа хэлний, ерөөс уран дүрслэлийн хамгийн хийсвэржсэн үндэстний соёл сэтгэлгээний онцлог, ончийг илэрхийлсэн чухал хэсэг байдаг ажээ. Уран дүрслэлийн хэтрүүллийн арга ихэсгэл, багасгал гэсэн хос эсрэгцсэн аргын нэгдэл юм. Юмс үзэгдлийн аль нэг шинж чанарыг бодитой байж болох хэмжээнээс нь хэт ихэсгэн давуулж, хүч чадал, мөн чанарыг нь зориуд нэмэгдүүлэн дүрслэх аргыг ихэсгэл, юмс үзэгдлийн аль нэг шинж чанарыг бодитой байж болох хэмжээнээс нь хэт багасган дутааж, хүч чадал, мөн чанарыг нь зориуд бууруулан дүрслэх аргыг багасгал гэдэг байна.

Ертөнцийн зарим зүйлсийн зүй тогтол, түүнийг ажиглаж ухаарсан хүний ухаарлаас ихэсгэл, багасгалын тухай ойлголт үүдэлтэй аж. Тодруулбал, ертөнцийн аливаа зүйлс ихсэх-багасах хөдөлгөөний орчилд оршино. Далайн давлагаа салхины аясаар ихсээд эргээд багасна, салхи ширүүсээд эргээд намдана, бороо асгараад буцаад татарна, өвс ногоо ургаад дараа нь хагдарна, хүн ч өсөж том болоод эцэст нь өвгөрч жижгэрнэ. Хорвоогийн энэ ихсэх, багасах хөдөлгөөн бүгд өөрийн зүй тогтол, давтамжтай. Энэ хөдөлгөөн, давтамж нь тухайн зүйлийнхээ орших үндэслэл нь болно. Байгалийн ихсэх, багасах хөдөлгөөний энэ зүй тогтол, мөн чанарыг хүн ажиглаад тэрхүү ажиглалтаа хэлэндээ, улмаар илэрхийлэлдээ ашиглаж уран дүрслэл бүтээдэг байна. Тиймээс ихэсгэл, багасгал хэл ярианд хийгээд уран дүрслэлд тодорхой арга болон төлөвшиж, тогтолцоо үүсгэсэн гэсэн үг. Шүлэгт ихэсгэл, багасгалын аргыг зөв ашигласан тохиолдолд гүн утга илэрхийлж, уран яруу дүрслэл бүтээдэг байна.

## **II. Монгол шүлэгт ихэсгэл, багасгалын аргаар уран дүрслэл бүтээж ирсэн туршилага, зүй тогтол**

### **II. I. Монгол аман зохиолын шүлгүүдэд ихэсгэл, багасгалын аргаар уран дүрслэл бүтээсэн нь**

Үндэстний зан заншил, соёл сэтгэлгээний өвөрмөц илэрхийлэл нь уран дүрслэх аргаар нь илрэх тул аливаа улсын уран зохиол өөрийн өвөрмөц онцлог, яруу сайхан шинжтэй байдаг. Монголын аман болоод бичгийн уран зохиолд уран дүрслэлийн олон аргаар яруу дүрслэл бүтээж ирсэн түүхтэй. Уран дүрслэлийн ихэсгэл, багасгалын арга нь юмс үзэгдлийн аль нэг шинж чанарыг бодит байх бололцооноос нь хэт ихэсгэж, эсвэл хэт багасгаж дүрслээд уншигчдын анхаарлыг гайхшируулан татах, эсвэл хошин аясаар айдас хүйдэст автуулах зорилготой тул ертөнцийн болоод хүний мөн чанар, аж амьдралын жам ёс, мөн чанарыг бодитой өгүүлдэг зүйр цэцэн үг, оньсого, ертөнцийн гурав, ардын дуу зэрэг нийтлэг төрөл зүйлүүдэд энэ аргыг бараг хэрэглэдэггүй байна. Харин дэлгэрүүлэх утгатай магтах сайшаах зорилготой бэлгэ дэмбэрлийн үг, ерөөл, магтаал, харилцан бие биеэ гартаах, давах зорилготой харилцаа шүлэг<sup>2</sup> буюу дайралцаан, хурим найрын зан үйлийн яруу найраг, баатарлаг туульс зэрэг төрөл

<sup>2</sup> Монгол аман зохиол болоод бичгийн яруу найрагт харилцаа шүлэг зохиол, харилцаат яруу найраг зэрэг нэр томъёо түгээмэл буй. Энэхүү харилцаа шүлэг зохиол, харилцаат шүлэг найраг гэсэн нэр томъёог уншигчид төдийгүй мэргэжлийн судлаачид ч төдий л ялгаж салгалгүй явж ирсэн билээ. Харин судлаач Ю.Мөнх-Амгалан эмхэтгэж, удиртгал, тайлбар бичиж хэвлүүлсэн “Монголын орчин үеийн харилцаат яруу найраг” (2020) бүтээлийнхээ удиртгалд “Харилцаа шүлэгт ая хийвэл даруй харилцаа дуу болон хувирдаг тул монгол ардын харилцаа дуу, харилцаа дуулал, харилцаа шүлэг зэргийг нэгтгэн ерөөсөө харилцаа яруу найраг гэж нэрлэж болох юм. ... нэг зохиолд холбогдсон, өөрөөр хэлбэл нэг зохиолд хариу болгосон шинжтэй хоёр зохиолчийн хоёр өөр зохиол хоёр өөр цаг үед бичигдсэн байна. Эдгээр зохиолыг ялган бүлэглэж, нэгэн ерөнхий хэв шинж, нэгдсэн тогтолцоонд оруулж үзэх шаардлагатай бөгөөд иймэрхүү зохиолыг логик холбоогоор нь төрөл зүйл буюу жанрынх нь талаас эхний удаад харилцаат яруу найраг гэж нэрлэвэл зүйтэй санагдана.” (10, 12 дугаар тал) хэмээн тодорхойлж хоорондын ялгааг шинжийг тодруулсан байна. Бидний ажиглалт, бодлоор бол харилцаа шүлэг найраг, харилцаат

зүйлүүдэд ихэсгэл, багасгалын аргыг түлхүү ашигласан онцлогтой байна. Тухайлбал, Бэлгэ дэмбэрлийн үгт:

Эсгий хийж байхад,

*Дэлхийн чинээ  
Дэвжээтэй бол  
Уулын чинээ  
Унгастай бол*

Хүү, охиндоо өмч болгож мал сүрэг өгөхдөө,

*Тоо нь түм хүртүгэй  
Тоос нь огторгуйд тултугай*

Гүү барьж байхад,

*Зэллэсэн унага нь  
Зээр гөрөөснөөс олон болж  
Ногтолсон унага нь  
Ногтруу шувуунаас олон болж  
Ногтондоо номхорч  
Чагтандаа чангарч  
Хулан чихтэй мэт*

*Хурдан хүлгүүд болтугай* (Цэрэнсодном, 2012:42-43)

гэх зэргээр үгийн хүч, ид чадлаар дамжуулан тухайн үйлийг дэлгэрүүлэн сайн сайхан байхыг хүсэх хүсэлтэй уялдуулан тухайн үйлийг бодит байх хэмжээнээс нь хэтрүүлэн ихэсгэж хэлсэн байна. Энэ нь ихэсгэлийн аргыг дүрслэгдэхүүний шинж чанар, тоо хэмжээг сайжруулан нэмэгдүүлэх хүслэнт сэтгэлийн үүднээс ирээдүйд хандсан дэлгэрүүлэх үйлийг өгүүлэхэд голчлон ашигладаг болохыг харуулах ба бэлгэ дэмбэрлийн үгэнд ихэсгэлийн аргыг түлхүү ашигладаг болохыг гэрчилж байна. Бэлгэ дэмбэрлийн үгийн эсрэг утга агуулгатай хараал зүхлийн үг зэрэгт тухайн зүйлийг муутгах, шинж чанар, тоо хэмжээг нь эрс бууруулах зорилготой уялдан уран дүрслэлийн багасгалын аргыг тодорхой хэмжээгээр ашигласан онцлог ажиглагдаж байна.

Ихэсгэл, багасгалын аргыг хосолмол хэлбэрээр харилцаа шүлэг найрагт түгээмэл ашигладаг байна. Тухайлбал, Дайралцаанд:

*Зэ! Хүү минь тийм үү дээ  
Зурман тааны нүхэнд нь  
Зургаан салаа байна уу даа  
Зулзаган чиний цээжинд нь  
Зургаан шүлэг байна уу даа ...  
Зэ! Хүү минь тийм үү дээ  
Сарыг харваад алдвал  
Саадаг бариад юу хийнэ  
Чамтай хэлэлцээд гартвал  
Шүлэг холбоод юу хийнэ ...* (Цэрэнсодном, 2012:337)

---

шүлэг найраг гэдэг нэр томъёог ончтой тодорхойлж, хоорондын ялгаа заагийг нь зөв гаргажээ гэж үзэж байна. Тиймд цаашид харилцаа шүлэг найраг, харилцаат шүлэг найраг хэмээх ойлголтыг судлаач Ю.Мөнх-Амгалан багшийн тодорхойлсноор нэрлэж занших нь зөв юм гэсэн саналыг дэвшүүлж байна.

гэх зэргээр дайралцагч хоёр тал бие биеэ үгээр гартаан давах зорилготой тул эсрэг талын этгээдийн бие эрхтний чадал чансаа, эрдэм ухааныг багасган, өөрийн чадал чансаа, эрдэм билгийг ихэсгэн дөвийлгөж өгүүлсэн байна. Энэ нь уран дүрслэлийн ихэсгэл, багасгалын аргыг аливаа зүйлийн шинж чанар, тоо хэмжээг ихэсгэх, багасгах зорилготой үед түлхүү ашигладаг болохыг харуулна. Тэгвэл харилцаат шүлэг найргийн гол дурсгал болох хурим найрын зан үйлийн аман зохиол дахь “Сүй морины ерөөл” (бэлгийн морины ерөөлийн үгсийг бэргэд нар хэлэлцэх тул Үзэмчин зэрэг газар “Бэргэдийн шангийн үг” гэж нэрлэдэг байна) хэлэлцэх үеэр бэлгийн морийг,

Хүүгийн тал:

*-Муу хүн унадаггүй  
Муруй шонгоос уядаггүй  
Цөөн адуунд тогтдоггүй  
Цөөрөм уснаас уудаггүй  
Ганзага болсон чихтэй  
Гархи болсон нүдтэй  
Заамал зургаан хүзүүтэй  
Заан дөрвөн соёотой  
Оломгүй, ооныг гүйцдэг  
Хударгагүй хуланг гүйцдэг  
Уулан дээгүүр гараад ирэх нь  
Усны долгио мэт  
Тал дээгүүр гараад ирэх нь  
Тас шувуу мэт ...*

Хүүхний тал:

*-Уул харах нүдгүй  
Лууль харах шүдгүй  
Барьж мордох дэлгүй  
Батгана үргээх сүүлгүй  
Бүрэнхийд үзэгдэхгүй  
Бүдэг зүстэй  
Харанхуйд үзэгдэхгүй  
Хачин зүстэй ... (Д.Цэрэнсодном, 2012:331)*

хэмээн дүрслэгдэхүүний шинж чанарыг магтагч тал ихэсгэн, муулагч тал багасган өгүүлсэн байна. Энэ нь уран дүрслэлийн ихэсгэлийн арга аливаа зүйлийн шинж чанарыг давуулан ихэсгэх шинжийг чухалчилдаг тул магтаал сайшаалын агуулгатай дүрслэлд түлхүү ашиглагддаг, багасгалын арга аливаа зүйлийн шинж чанарыг бууруулан багасгаж, хошин өнгө аястай илэрхийлэх тул шүүмжлэх муулах агуулгатай дүрслэлд түлхүү ашиглагддаг онцлогтойг харуулж байна. Монгол аман зохиол дахь харилцаа шүлэг найраг нь харилцагч талууд бие биеэ давах, гартаах зорилготой тул уран дүрслэлийн ихэсгэл, багасгалын аргыг хос эсрэгцлийн төгс хослол дунд нь урнаар ашигладаг ба тэр хэмжээгээрээ уг дүрслэлийн аргын онцлог, зүй тогтол илүү тодорхой товойн харагддаг байна.

Уран дүрслэлийн хэтрүүллийн аргыг хамгийн өргөн дэлгэр ашигласан аман зохиолын зүйл бол баатарлаг тууль юм. Тухайлбал, “Жангар” туульд: Жангар баатрын,

Баян Хүнхээн Алтан Цээжийг нь:

*Ирсэн ерэн есөн жилийн юмыг  
Тоочиж хэлдэг  
Ирээгүй ерэн есөн жилийн юмыг  
Тааж мэддэг ... (2008:15),*

Агай Шавдал хатныг нь,

*Цаашаа харахад нь  
Цаад далайн жараахай тоологдом  
Наашаа харахад нь  
Наад далайн жараахай тоологдом  
Цуснаас улаан хацартай  
Цаснаас цагаан санчигтай ... (2008:18),*

Агай Шавдал хатны хуурдахыг нь,

*Ерэн нэгэн чавхдастай  
Ендэр мөнгөн хуураа аваад татахлаар  
Хулсан дунд өндөглөсөн  
Хунгийн дуу гараад  
Нуур дунд өндөглөсөн  
Нугасны дуу гараад  
Арван хоёр аясаар  
Хангинаад гарав ... (2008:18-19),*

Гүзээн Гүмбэ баатрыг нь,

*Тавлаад суухлаараа  
Тавин хоёр хүний зайд суудаг  
Тахийгаад суухлаараа  
Хорин хүний зайд суудаг ... (2008:20),*

Жангарын хүлэг морийг нь,

*Зургаан төө чихээ  
Зуур зуур солбиод  
Өрмийн иш соёогоороо  
Өлгий мөнгөн зуузайг хавираад ... (2008:35),*

гэх зэргээр Жангарын хүлэг баатар Алтан Цээжийг өнгөрсөн болоод ирээдүйн ерэн есөн жилийн юмыг тааж мэддэг, Агай Шавдал хатныг нь нар сарнаас гэрэл гэгээтэй сайхан зүс царайтай хийгээд байгалийн ямар ч хөг аялгуунаас илүү сайхнаар хуурддаг, Гүзээн Гүмбэ баатрыг нь хэн хүнээс илүү том товир, хүлэг морийг нь чихээр нь төлөөлүүлэн том товир, хүч чадалтайг нь хэт ихэсгэн уран дүрслэл бүтээжээ. “Жангар” тэргүүтэй монгол туульд энэ мэтээр ихэсгэлийн аргыг түлхүү ашигласан ч цөөнгүй газар баатрын аймхай дорой, хүч чадалгүй зэрэг сөрөг үнэлэмжийг нь илэрхийлэх зорилгоор багасгалын аргыг ч тодорхой хэмжээгээр ашигласан байна. Энэ нь уран дүрслэлийн ихэсгэлийн аргыг дүрслэгдэхүүнийг магтах сайшаах, нэмэн дэлгэрүүлэх агуулга бүхий дүрслэлд бодит байгаа шинжээс нь хэтрүүлэн дэлгэрүүлэх үед түлхүү ашигладаг бол тэрхүү хэтрүүлэн дэлгэрүүлсэн зүйлстэй эсрэгцүүлэн эсрэг талын зүйлсийн шинж чанарыг бууруулах муутгах зорилгоор багасгалын аргыг түлхүү ашигладаг болохыг харуулж байна. Уран дүрслэлийн ихэсгэл, багасгалын аргыг монгол ардын аман

зохиолд тэр дундаа баатарлагийн туульс (үлгэр, домог)-г түгээмэл ашиглаж байжээ. Энэ нь эртний хүмүүсийн сэтгэлгээнд хүч чадалтай, том товир бие бялдартай байвал, эсвэл сул дорой, жижиг бяцхан хэмжээтэй байвал байгалийн сүр хүч хийгээд өрсөлдөгч дайснаа амархан дарж, эсвэл өрөвдүүлж чадна гэсэн ойлголт байсан үеийн тусгал болтой.

Ардын дууны үгийг хэтрүүллийн аргаар бичсэн нь харьцангуй цөөн байна. Цөөн гэдгийн учир нь ардын дуунд бодит зүйлийн мөн чанар, ахуй соёл, түүний илрэлийг учирлан өгүүлэх тул тэнд хэтрүүллийн аргыг ашиглах шаардлага байсангүй. “Хүүхэн хутагтын дуу” зэрэгт,

*Гучин гурван шарга морины*

*Гурваас бусад нь усан тэлмэн жороо ...* (Цэдэв, 1995:100) хэмээн монголчуудын чухалчлан хэрэглэж заншсан тоог хэтрүүлэн өгүүлж, хэтрүүллийн дүрслэл тодорхой хэмжээгээр үүсгэсэн байна. Энэ нь уран дүрслэлийн хэтрүүллийн аргыг үндэстний соёл сэтгэлгээнд чухал үнэлэмжтэй тоо, хэмжээ зэргийг ашиглаж дүрслэл бүтээдэг уламжлал буйг харуулж байна. Уран дүрслэлийн хэтрүүлэл болох ихэсгэл, багасгалын хос эсрэгцсэн арга нь монгол аман зохиолын зарим төрөл зүйлүүдэд юмсын дотоод мөн чанар, шинж чанар, тоо хэмжээг солин нэрлэх маягаар уран дүрслэл бүтээсэн онцлогтой байна.

## **II. II. Монголын эртний бичгийн уран зохиолын шүлгүүдэд ихэсгэл, багасгалын аргаар уран дүрслэл бүтээсэн нь**

“Монголын Нууц Товчоо”-ны 195 дугаар зүйлд Жамуха Найманы Таян ханд Тэмүжиний дөрвөн нохдыг,

*Siremün manglaitan*

*Si'üci qosi'utan*

*Sibüge keleten*

*Temür öreten*

*Üldü mina'atan*

*Si'üder-i idejü*

*Kei unuju yabut tede*

*Alalduqui üdür*

*Haran-u miqa idet tede*

*Gürülcegü üdür*

*Gü'ün-ü miqa günesület tede ...* (Rachewiltz, 1972:104),

Тэмүжинг,

*Ene ayisqu temüjin anda minu*

*Gü[b]cin beye inu siremü-'er sirekdeksen*

*Sibüge-de qatququi-a cölö üge(i)'ü*

*Temür-iyer dabtaqsan*

*Tebene-de qatququi-a cölö üge(i)'ü*

*Temüjin anda minu öyeseksen sibawun metü eyin*

*Sile-meljen ayisu-lu üjebe-yü'ü ta* (Rachewiltz, 1972:105),

Хасарыг,

*Qurban alda beyetü*

*Qunajin bodo idesitü*

*Qurban dabqur quyaq emüscü*



*Qurban buqa jitgü 'üljü ayisu-je*  
*Qortu gü 'ün-i qotola-yi jalgi 'asu*  
*Qo 'olai-dur-iyān ülü tordayu*  
*Gübcin ere-yi emgü 'esü*  
*Öre ülü jasayu ... (Rachewiltz, 1972:105),*

гэх зэргээр Найманы Таян хаантай байлдахдаа Чингис хаан “Олноос олон, цөөнөөс цөөн хор хохирол болмуу зэ” хэмээн хэлж өөрийн цэргээ манлайлан довтлох үе дэх Зэв, Хубилай, Зэлмэ, Сүбээдэй нарын Чингис хааны дөрвөн ноход гэж нэрлэгддэг баатруудын сүр хүч, эр зоригийг “зүү хатгах зайгүй төмөр хуяг дуулгаар өвч биеэ бүрсэн, хүний махаар хүнс хийн, шүүдэр идэж, хий унаж явдаг” хэмээн Жамуха Таян ханд хандаж уран дүрслэлийн ихэсгэлийн аргаар гайхалтай яруу танилцуулсан байна. “... шүүдэр идэж, хий унаж явуут, тэд” гэсэн үгс нүүдэлчний яруу найраг дахь хийсвэр сэтгэлгээний гоц баримт болно. Өвсөн толгойд тогтсон шүүдэр дэгдээд ам руу нь орно гэдэг салхи хөлөглөж яваа аагтай морьтны дүрийг аргагүй л тодруулж байна. Шүүдрийг иднэ гэдэг баригдашгүйг ч үл гаргаах цог залиг нь, хий унана гэдэг замдаа таарсан бүхнийг арчаад өнгөрөх сүр хүчийг нь товойлгож, энэ дүрслэлээс онгодын амьсгалаар эгшин зуурт таталгасан бэхэн зураг үзэгдэх шиг болдог. Тийм л салхитай бичжээ” (Аюурзана, 2016:198). Жишээ татсан хоёр дахь шүлэгт Тэмүжинийг “хөвчин биеэ шөвөг хатгах зайгүй төмрөөр бүрж, шунган орох шувуу шиг дүүлж явна” хэмээн дөрвөн нохдын нь адил түүний сүр хүч, байлдаанч байдлыг ихэсгэлийн аргаар дөвийлгөн бичжээ. Тэгвэл Хасарын байр байдал, сүр хүчийг монгол ардын баатарлаг туульсын баатар эрчүүдийн адилаар “гурван алд биетэй, гунжин бодын идэштэй, гурван давхар хуяг өмссөн, хоромсогот хүнийг хотлоор нь залгихад хоолойд нь үл тордог, хөвчин эрийг үмхвээс өл үл залгадаг” хэмээн хэтрүүлэн дүрслэсэн байна. Уран дүрслэлийн хэтрүүллийн арга ихэсгэл, багасгал гэсэн хос эсрэгцсэн аргын нэгдэл. “Монголын Нууц Товчоо” зохиолд ихэсгэлийн аргын эсрэгцэл болох багасгалын аргыг ч түгээмэл ашигласан байна. Тухайлбал, 194 дүгээр зүйлд,

*Kündü eme-yin si 'ekui qajar-a ese qaruqsan*  
*Gürdün-ü tuqul-un belji 'el-tür ese güriksen*  
*Eme tayang jirüge yadarun ese- 'ü*  
*Ede üges ügülejü ilējü 'üi ... (Rachewiltz, 1972:102)*

хэмээн Хүчүлүг хан эцэг юүгээн “жирэмсэн эмийн шээх газар, жижиг тугалын бэлчих бэлчээрээс хол явж үзээгүй” гэж хэтрүүлэн багасгаж өгүүлснийг зохиолд “эцгийнхээ сэтгэлийг өвдтөл, хорстол өгүүлжээ” хэмээн тодотгосон байна.

Энэ бүхэн бол юуны өмнө “Монголын Нууц Товчоо”-г ардын аман зохиолын бичлэг, туурвил зүйн аргын үүднээс бичсэнийг, улмаар эртний монголын уран зохиолд хийсвэрлэн сэтгэх нь уран дүрслэлийн аргуудын язгуур хөрс суурь болж байсныг харуулж байна. Нөгөө талаар ихэсгэл, багасгалын арга нь дүрслэгдэхүүний сүр хүч, эр зориг хийгээд аймхай хулчгар, жижиг бядуу тэргүүтнийг дөвийлгөх юм уу бууруулан гаргаж, тэрхүү хэт дөвийлгөн, хэт бууруулан гаргасан дүрслэлээр эсрэг талын этгээдийг айлган сүрдүүлэх, буруутган муутгах нэг арга болж байсныг харж болохоор байна. Уран дүрслэлийн ихэсгэл, багасгалын аргыг ашиглаж эсрэг талдаа хүчтэй дарамт шахалт үзүүлэх, түүнийг уруудуулан доройтуулах нь үгийн хүч чадал, увдис шидийн гайхамшгийг харуулж байгаа хэрэг. Энэ бүхэн бол ихэсгэл, багасгалын арга нь ардын аман зохиолоос уламжлалтай үгийн хүнд нөлөөлөх нөлөөг уран дүрслэлд ашиглаж уран яруу илэрхийлэх нэгэн зүйл тогтолцоот арга байсныг харуулж байна. Хэтрүүлэл нь зохиол уншихад амт нэмж, уншигчийг татах хүч болдог байна. Энэ нь уншигчийн язгуур мөн чанарт байгаагаасаа ямагт их рүү тэмүүлж, төсөөлдөг төсөөлөлтэй нь, нөгөө талаас эсрэг талаа ямагт байгаагаас нь бууруулан мөрөөдөх мөрөөдөл, төсөөлөлтэй нь холбоотой болтой.

Лувсанданзаны “Алтан товч”-д,

Чингис хааныг Мухулай жанжин,

*Amta-du [=amtatu] olan jimis delgeregsen g'albarawaras modun minu*

*Asuru erke kücün tegüsügsen časutu ayula-yin čayan arslan minu*

*Ary-a kücün qoyar-i tegsi čidayči g'arudi kölgetü minu*

*Aldar-tu [=aldartu] törügsen suta boyda ejen minu ...* (Чоймаа, 2011:201)

хэмээн магтсан хэсэгт Чингис хааныг “амтаг олон жимс дэлгэрсэн галбарваас мод”, “асар эрх хүчин төгссөн цаст уулын цагаан арслан”, “арга хүчин хоёрыг тэгш чадагч гарьд хөлгөт” хэмээн уран дүрслэлийн төлөөллийн арга, далд адилтгал зүйрлэлийн арга болоод ихэсгэлийн аргын шүтэлцээгээр тэнгэрийн оронд байдаг арвин баялаг жимс дэлгэрсэн домгийн том мод лугаа адил хэмээн буян хишиг, нөмөр нөөлгийг нь, цаст уулын цагаан арслан мэт хэмээн хүч чадал, эр зоригийг нь, хүний амьдрал дахь муу муухайг даран сөнөөгч алтан жигүүрт домгийн хүчит гарди шувуу адил хэмээн суу заль, арга ухаан болоод хүчин чадал төгсийг нь ихэсгэлийн аргаар өвөрмөц уран дүрсэлжээ. Энэ нь монгол шүлэгт нэг дүрслэлийг уран дүрслэлийн олон аргаар тал бүрээс нь төгс хослол дунд нь яруу дүрсэлж болдог онцлогийг харуулж байна. Тэгвэл энэхүү “Алтан товч” зохиолд,

*Körjim-tü [=körjimtü] časun-i köl-iyer etüjü*

*Kölüsütü toqum-i següji-ber egsiyeyü*

*Sidün-ü sigidüsün-i [=sigidüsün-ü] tedüi-ber qonuyajü*

*Silüsün-ü tedüi-ber undalajü ...* (Чоймаа, 2011:218)

хэмээн Ухурдай Сараманы өгүүлсэн үгэнд Чингис хаанд нэгэн үзүүрт сэтгэлээр хүчээ өргөхдөө явган нүцгэн явж, хаа хэрэгтэй газар нь очиж, “шүдэнд шигдсэн төдийгөөр хооллож, шүлсээрээ ундалж” явсан хэмээн монгол аман зохиолд хэвшин тогтсон байдаг багасгалын уран яруу дүрслэлийг бүтээлчээр уламжлан яруу дүрслэл бүтээсэн байна.

Дээрх хоёр жишээ шүлгийг эс тооцвол Лувсанданзан “Алтан товч” зохиолдоо уран дүрслэлийн ихэсгэл, багасгалын аргыг ашиглаагүй байна. “Монголын Нууц Товчоо” зохиолд байдаг ихэсгэл, багасгалын аргаар дүрслэгдсэн яруу дүрслэлүүдийг ч уламжилж авсангүй. “Жангар” тэргүүтэй монгол ардын баатарлаг туульст баатар эрчүүдийн алдар гавьяа, суу залиг магтан сайшаахдаа уран дүрслэлийн ихэсгэл, багасгалын аргыг түгээмэл ашигласан байдаг бол Лувсанданзаны “Алтан товч” тэргүүтэй XVII-XVIII зууны үеийн зохиолуудад Чингис хаан болоод түүний өрлөг жанждын үйл хэрэг, ур ухааныг магтан сайшаахдаа (“Гурван зуун Тайчуудыг дарсан домог”, “Чингисийн есөн өрлөгтэй өнчин хүүгийн цэцэлсэн шасдир”, “Аргасун хорчийн домог”, “Мандухай цэцэн хатны тангаргийн шүлэг” зэрэг) уран дүрслэлийн ихэсгэл, багасгалын аргыг бус уран дүрслэлийн адилтгал зүйрлэлийн арга, төлөөлөл тойрууллын аргыг түлхүү ашигласан байна. Энэ нь XVII-XVIII зууны үе болоход аливаа зүйлийг байгаагаар нь бодитой шүлэглэх байдал зонхилох болсон онцлогийг харуулж байна. Энэ онцлог шинж XIX зууны монголын уран зохиолд ч зонхилж байжээ.

### II. III. Монголын орчин үеийн уран зохиолын шүлгүүдэд ихэсгэл, багасгалын аргаар уран дүрслэл бүтээсэн нь

Дүрслэгдэхүүний байгаа байдлыг хэтрүүлэн дүрслэх маягаар аль нэг талыг тодруулан нээж, улмаар уншигчдын анхаарлыг ихэсгэсэн юм уу, багасгасан дүрслэгдэхүүнээрээ татах зорилготой энэ аргыг бодит зүйл, баримтат дүрслэгдэхүүнийг чухалчлан үзэх болсон орчин цагт харьцангуй бага хэрэглэх болсон нь Д.Нацагдорж, Б.Явуухулан, Б.Лхагвасүрэн нарын шүлгийн түүврээс тодорхой харагдаж байна.

Д.Нацагдорж “Нойрон дунд” шүлэгтээ,

*Хөдөлсөн хүсэл хэрмийн дээр*

*Хүүхний толгой дэрний дээр*

*Гудамжны жавар тас няс*

*Янагийн халуун 40 градус ... (2016:122)*

хэмээн тоо ашиглаж хэтрүүлэл үүсгэсэн байна. Д.Нацагдоржийн шүлгүүдэд “Нойрон дунд” шүлгээс нь өөр хэтрүүллийн аргыг ашиглаж уран дүрслэл бүтээсэн шүлэг алга байна. “Орчин цагийн уран зохиолд (шүлэгт Г.Г.) уг үзүүлж байгаа юм үзэгдлээ бодит байдалд байгаа тэр хэмжээгээр нь дүрслэн үзүүлэх реалист арга нэвтэрсний улмаас хэтрүүллийг цөөн хэрэглэх болсон нь зүй ёсны хэрэг” (Отгонсүрэн, 1984:30) байж болох юм.

Б.Явуухулан “Би чамд хайртай” шүлэгтээ,

*Холоос гүйдэлтэй борлог минь*

*Сулдаа ганхам жороо доо*

*Голоос хайртай амраг минь*

*Шөнөдөө гэрэлтэм царайлаг даа ... (1985. 174)*

хэмээн холын замд улдаа нь үгүй сайн хүлгийнхээ явдлыг жороо сайхан, сэтгэлийн гүнд гэрэлтсэн хайртай бүсгүйнхээ гоо сайхныг шөнө ч гэрэлтмээр хэмээн монгол тууль дахь хүлэг мориныхоо хүч чадал, хүүхэн хонгорынхоо үзэсгэлэнт царайг хэтрүүлэн өгүүлдэг уламжлалыг орчин үежүүлэн бодит ахуй нөхцөлтэй нь уялдуулан урнаар дүрсэлсэн байна. Мөн “Шилийн богд уул” шүлэгтээ,

*Шилийн богд уул*

*Талын намхан уул юм*

*Шилийн богд уул*

*Домгийн өндөр уул юм*

*Ойр орчмоос нь харахад*

*Оонын эвэр цухуймаар*

*Тоорой бандийг нуумааргүй*

*Тойгийн чинээ намхан юм*

*Орой дээр нь гарахад*

*Орчлонгийн зах харагдмаар*

*Сүүмийх алс цэнхэрлэсэн*

*Сүмбэр их өндөр юм (1985:320)*

хэмээн Шилийн богд уулыг зэрвэс харахад талын намхан уул ч монгол түмний сэтгэл, урлаг уран зохиолд бол сүмбэр өндөр уул гэдгийг урнаар өгүүлээд тэр санаа-дүрслэлээ дараагийн бадагтаа эр бяр, эрдэм ухааны эд хаваараа Монгол даяар алдаршсан Торой банди унаж явах морь, тууж явах сүрэгтэйгээ энэ ууланд нуугдаж, нутаглаж, тэр хэмжээгээр энэ уулыг алдаршуулан цуурайтуулж асан гэх ч хажуу талаас нь харахад цаад талд нь бэлчиж яваа оонын эвэр цухуймаар намхан уул байна хэмээн хэтрүүлэн багасгаж дүрсэлсэн бол дараагийн бадагтаа уг жижигхэн уулын орой дээр нь гарвал орчин тэр чигээрээ харагдмаар, гайхам сайхан харуултай сүмбэр их өндөр уул (“Богд” хэмээн энгийн ямар ч уул, хайрхнаас өндөр гэсэн утгатай. Г.Г.) болохыг өмнөх бадгийнхаа багасгасан дүрслэлтэйгээ эсрэгцүүлэл үүсгэн уран дүрслэл бүтээсэн байна. Энэ дүрслэл нь ихэсгэл, багасгалын арга түүхэн хөгжил хувьслын явцдаа цаг үеийн шаардлагаар бие биедээ уусан ижилсэж, эсрэгцэл үүсгэх маягаар уран дүрслэл бүтээх болсон онцлогийг харуулж байна. Өөрөөр хэлбэл, орчин үед уншигч хийгээд яруу найраг бодит зүйлд илүү анхаарах сэтгэлгээ зонхилох болсон тул ихэсгэл, багасгалын

арга хэт ихэсгэх, хэт багасгах шинжээ ойртуулан бие биедээ уусах маягаар өвөрмөц эсрэгцсэн уран дүрслэл бүтээх болсон байна. Энэ нь цаанаа хэтрүүллийн аргын түүхэн хөгжилд гарсан өөрчлөлт, шинэчлэлтийг харуулж байна.

Уран дүрслэлийн ихэсгэл, багасгалын аргад гарсан өөрчлөлт Б.Лхагвасүрэнгийн зарим шүлгүүдээс тод ажиглагдаж байна. Тухайлбал, “Ижийтэйгээ байхад” шүлэгт нь,

*... Орилсоор ижсүйдээ очин нулимсаа арчуулахад  
Одод бүгдээрээ миний нүдэн дотор түгдэг байсан  
Ижсүй минь инээгээд над руу ирэхэд  
Энэхэн замбуутивийн наран над дээр л асгардаг байсан  
Ижсүйтэйгээ байхад би баян байсан  
Араг үүрсэн ижсүйнхээ ар өвөрт гүйхэд  
Аараг толгодын элс алтаар нурдаг байсан  
Бөртөн бөртөн зэрэглээ хормойтой минь орооцолдож  
Бүжин бор хөлийн минь сайрыг долоодог байсан  
Ижсүйтэйгээ байхад би баян байсан  
Судас нь лугшиж халуу дүүгсэн  
Бурхны өвөр дээр тоглодог байсан  
Сүнс зайлам харанхуйн дунд  
Сүү нөмөрч унтдаг байсан ... (2006:14)*

хэмээн үрээ гэх агуу сэтгэлээр бялхсан ээжийнхээ дэргэд байх хүүхдэд орчлонгийн бүх зүйл хамгийн сайн сайхан утга, мөн чанараараа ирдэг тул үр хүүхдэд нь айдас хүйдэсгүй, амар тайван байдаг жам ёс, мөн чанарыг найрагч өөр дээрээ буулган ээжийнхээ хайранд өлгийдүүлж асан энхрий багад нь орчлонгийн бүх од нүдэнд нь түгж, нарны туяа бүхлээрээ биед нь шингэж, араг толгодын элс ч алтны үнэ цэнээр ирсэн жаргал цэнгэл шиг дулаан зөөлөн байдаг байсан хэмээн ээжийнхээ дэргэд байсан бага насны жаргал цэнгэлээ ихэсгэн дүрслээд тэрхүү хэтрүүлээ нүдний үзүүрт торолзох зэрэглээний торгон долгиог хажуудаа татан багасгасан дүрслэлтэй уялдуулан эхийн хайрын үнэнд уусган урнаар дүрсэлсэн байна. Б.Лхагвасүрэн найрагчийн ихэсгэл, багасгалын аргыг хооронд нь уусган уран дүрслэл бүтээсэн онцлог нь ихэсгэл, багасгалын аргын түүхэн хөгжилд гарч байгаа өөрчлөлт, дүрслэгдэхүүний мөн чанар, зүй тогтлыг илэрхийлж байна.

Монгол ардын аман зохиолд ихэсгэл, багасгалын аргаар уран дүрслэл бүтээхдээ илэрхийлж байгаа зүйлээ илүү бодитой болгохыг хичээн эрмэлзэж дүрсэлсэн бол эрт, эдүгээгийн бичгийн шүлэг найрагт дүрсэлсэн зүйлийнхээ байгаа байдлыг хэт дөвийлгөх, хэт багасгах шинжийг нь голлон дүрсэлсэн онцлог ажиглагдаж байна. Уран дүрслэлийн ихэсгэлийн ур маягийг зөв ашиглаж чадвал дүрсэлж байгаа зүйлийн онцлог шинж хүчтэй товойн тодорч, тэр хэмжээгээрээ уншигчид гүн сэтгэгдэл төрүүлэх бол уран дүрслэлийн багасгалын ур маягийг зөв ашиглаж чадвал дүрсэлж байгаа зүйлийн онцлог шинж хэт багасаж хошигносон өнгө аяс орж, тэр хэмжээгээр уншигчийн анхаарлыг өөртөө хүчтэй татдаг онцлогтой байна.

### **Дүгнэлт**

- Уран дүрслэлийн ихэсгэл, багасгалын арга нь ертөнцийн зүй тогтол дахь ихсэх, багасах хөдөлгөөний давтамж, түүний зүй тогтлоос үүсэлтэй аж. Байгалийн ихсэх, багасах хөдөлгөөний зүй тогтол, мөн чанарыг ажиглаж зөв ухаарснаар хүн хэлний илэрхийлэлдээ, улмаар лавшруулан төгөлдөржүүлж уран зохиолд тэр дундаа шүлгийн уран сайхны дүрслэлийн тусгай арга болгон төлөвшүүлжээ.

- Ихэсгэл, багасгал нь үгийн үндсэн утгыг шилжүүлэн өөрчилж, өөр утга илэрхийлдэг уран дүрслэлийн арга аж. Энэ нь ихэсгэл, багасгалын арга нь юмсын дотоод мөн чанар, шинжийг тодруулан товойлгоход илүү ашиглагддаг онцлогтойг харуулж байна.

- Уран дүрслэлийн ихэсгэлийн ур маягийг зөв ашиглаж чадвал дүрсэлж байгаа зүйлийн онцлог шинж хүчтэй товойн тодорч, тэр хэмжээгээрээ уншигчид гүн сэтгэгдэл төрүүлэх бол уран дүрслэлийн багасгалын ур маягийг зөв ашиглаж чадвал дүрсэлж байгаа зүйлийн онцлог шинж хошигносон өнгө аястайгаар хэт багасаж, тэр хэмжээгээр уншигчийн анхаарлыг өөртөө хүчтэй татдаг онцлогтой байна. Энэ нь шүлэгт уран дүрслэлийн эсрэгцсэн хос арга болох ихэсгэл, багасгалын аргыг ончтой зөв ашиглаж чадвал шүлэгт гүн утга илэрхийлж, уран сайхан чанар нь нэмэгддэг болохыг харуулж байна.

- Зохиолын баатрын дүрийг хүч чадалтай, том товируун зэргээр эерэг үнэлэмжийг нь нэмэгдүүлэх зорилгоор ихэсгэлийн аргыг шууд хэрэглэсэн байгаа бол эсрэгээр нь дүрийг хүч чадалгүй, сул дорой, жижиг бяцхан зэргээр сөрөг үнэлэмжийг нь нэмэгдүүлэх зорилгоор багасгалын аргыг эерүүлэн хошигнох маягаар дам хэрэглэсэн онцлог ажиглагдаж байна.

- Уран дүрслэлийн ихэсгэл, багасгалын арга орчин үед уншигчдын бодит хийгээд баримтаг зүйлд илүү ач холбогдол өгөх болсон сэтгэлгээ, нийгмийн хөгжилтэй уялдан харьцангуй бага ашиглагдах болжээ. Ихэсгэл, багасгалын арга дүрслэл бүтээх явцдаа дүрслэгдэхүүнээ хэт ихэсгэх, хэт багасгах туйлын хязгаараа ойртуулан бие биедээ уусан идээшиж, тэрхүү уусан идээшсэн байдлаараа хэм тэгш эсрэгцсэн харьцаа бүхий уран дүрслэл үүсгэх болсон байна. Энэ нь уран дүрслэлийн ихэсгэл, багасгалын аргын хөгжил хувьсалд гарсан өөрчлөлт, шинэчлэлтийг харуулж байна.

### Номзүй

**Аюурзана Г.** 2016. *Тэнгэрийн судар*. GÜN publishing. Улаанбаатар.

**Байгалсайхан С.** 1995. *Уран зохиол шинжлэлийн удиртгал*. Шинжлэх ухааны хэвлэлийн “Эрдэм” компанийн хэвлэл. Улаанбаатар.

**Базаррагчаа М.** 2003. *Монгол хэлний сүгээр ба найруулбарын тухай*. МУИС-ийн хэвлэх үйлдвэр. Улаанбаатар.

**Баярсайхан Ц., нар.** 1990. *Монгол хэлний найруулгын төрөл*. Улсын хэвлэлийн газар. Улаанбаатар.

**Гаадамба Ш.** 1989. *Утга зохиолын онолын үндэс*. Улсын хэвлэлийн газар. Улаанбаатар.

**Галбаатар Д.** 2012. *Уран зохиол: онол, түүх, шүүмжлэл. Нэвтэрхий толь*. Улаанбаатар.

**Галбаяр Г.** 2020. *Монгол шүлэгт адилтгал зүйрлэлийн аргаар уран дүрслэл бүтээсэн зарим онцлог*. Хэл Зохиол Судлал, ЭШС. Боть XIII (45). 232-250. Улаанбаатар.

**Дандин.** 2014. *Зохист аялгуун толь*. Сонгон эмхэтгэж, ариутган шүүж хэвлүүлсэн Дожоогийн Цэдэв. “Интерпресс” хэвлэл. Улаанбаатар.

**Дулам С., Хасбаатар Ц.** 1980. *Уран зохиолын онолын үүд*. Сайд нарын зөвлөлийн улсын дээд тусгай дунд техник-мэргэжлийн боловсролын хорооны хэвлэл. Улаанбаатар.

**Лувсанданзан.** 2011. *Эртний хаадын үндэслэсэн төр ёсны зохиолыг товчлон хураасан алтан товч хэмээх оршвой*. Эх бичгийн цогц судалгаа хийж хэвлүүлсэн Ш.Чоймаа. Улаанбаатар.

**Лхагвасүрэн Б.** 2006. *Бүрэн түүвэр*. 3 боть. Улаанбаатар.

*Монгол Жангарын тууль*. 2008. Уламжлалт эхийг баримтлан нэмэн засварлаж шүлэглэсэн Цэндийн Дамдинсүрэн. “Содпресс” ХХК-ий хэвлэл. Улаанбаатар.

*Монголын орчин үеийн харилцаат яруу найраг*. 2020. Эмхэтгэж удиртгал, тайлбар бичсэн Ю.Мөнх-Амгалан. “Соёмбо Принтинг” ХХК-ны хэвлэх үйлдвэр. Улаанбаатар.

**Нацагдорж Д.** 2016. *Бүрэн зохиол*. Тэргүүн боть. Оршил, удиртгал өгүүлэл бичиж, зохиолчийн гар бичмэлийн сэргээлт, эх бичиг судлалын туршиц тайлбар, толь, ном зүй үйлдэн хэвлэлд бэлтгэсэн Дожоогийн Цэдэв. “Мөнхийн үсэг” ХХК-ий хэвлэл. Улаанбаатар.

- Отгонсүрэн Д.** 1984. *Д.Нацагдоржийн зохиолын хэл найруулга уран сайхны онцлог*. Улсын хэвлэлийн газар. Улаанбаатар.
- Сүхбаатар Ц.** 2007. *Монгол хэлний найруулга зүй*. “Удам соёл” ХХК-ны хэвлэл. Улаанбаатар.
- Цэдэв Д.** 1995. *Монгол эх бичгийг шинжлэх арга зүйн туршиу*. 東洋出版印刷株式会社 Токио.
- Цэрэнсодном Д.** 2012. *Монгол аман зохиолын тайлбарт дээж бичиг*. “Тод бичиг” ХХК хэвлэл. Улаанбаатар.
- Явуухулан Б.** 1985. *Түүвэр зохиол*. Улсын хэвлэлийн газар. Улаанбаатар.
- Kathleen Morner, Ralph Rausch.** 1998. *NTC's Dictionary of Literary Terms*. Published by The McGraw Hill Companies. New York.
- Rachewiltz Igor De.** 1972. *The Secret History of the Mongols*. Published by Indiana University. Bloomington.